

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4 - 6

1. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	4 - 6
2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	6

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 11-ний өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 44 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Ж.Батсуурь, С.Ганбаатар, Б.Жавхлан, Д.Өнөрболор;
Чөлөөтэй: Ч.Хүрэлбаатар, Б.Чойжилсүрэн.

Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Тэмүүлэн: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 5 минут үргэлжилж, 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 12 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
12 цаг 44 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Г.Амартүвшин гишүүн,
С.Одонтуяа гишүүн, Д.Тогтохсүрэн гишүүн,
Х.Баделхан гишүүн,
Ц.Даваасүрэн гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн,
Ж.Батжаргал гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүн,
Л.Мөнхбаатар нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж өнөөдрийн ирц бүрдсэн байна.

Ингээд Төсвийн байнгын хорооны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хоёр асуудал байгаа. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

2024 оны 03 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх эсэх асуудал байна.

Хоёр дахь нь, Байнгын хорооны тогтоолын төсөл байгаа.

“Цаглавар батлах тухай”.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

Нэг. “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай”

Улсын Их Хурлын тогтоолын төсөл

/Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 7 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Хууль санаачлагчийн танилцуулгыг миний бие танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Агаарын

бохирдлыг бууруулахтай холбогдуулан арга хэмжээн тоонд тогтоолыг баталсан бөгөөд тогтоолын 4 дэх хэсэгт зохист хэмжээнээс их хорт утаа ялгаруулж байгаа авто тээврийн хэрэгсэл зориулалтын бус түлш хэрэглэн, химийн хорт бодис ялгаруулж, агаарын чанар, нийгмийн эрүүл мэндэд хохирол учруулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тавих

хяналтыг чангатгаж, таслан зогсоох арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгасан.

Сүүлийн жилүүдэд хууль тогтоогчийн дээрх бодлого Үндсэн хуулиар тунхагласан хүний үндсэн эрх, эрх чөлөөг хөндсөн үйлдэл гарах боллоо.

Тухайлбал, автомашинаас ялгарах хорт утааг шүүх зориулалттай нүүрсэн янданг хулгайн аргаар болон сайн дураар худалдан борлуулах, улсын хилээр гаргах үйлдэл ихээр гарах болсон нь нийслэлийн агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх болсныг холбогдох судалгааны байгууллагууд танилцуулах болжээ.

Улмаар нүүрсэн яндангийн дамын наймааны төлөөлсөнд олон мянган иргэд, машин техник, өмч хөрөнгөөрөө, төв суурин газрын олон зуун мянган иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна.

Ингээд Монгол Улсад автомашины нүүрсэн янданг худалдан авдаг сүлжээ үүссэн бөгөөд Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу хил нэвтрүүлэн худалдан борлуулдаг байна.

Цагдаагийн байгууллагын мэдээллээс үзэхэд сүүлийн 4 жилийн байдлаар автомашины яндан алдагдсан дуудлага мэдээлэл 890-ээр бүртгэгдсэн байна.

Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээс үзэхэд жилд ойролцоогоор улсын хилээр катализаторын хаягдал нэрээр 27.5 тонн автомашины нүүрсэн янданг хилээр гаргасан байна.

Дээрх үндэслэлээр Монгол Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Улсын хилээр нэвтрүүлэх, хориглох тарифын бусад хязгаарлалт

тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай” 08 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт оруулж, автомашины нүүрсэн яндан болон нүүрсэн яндангийн хаягдлыг улсын хилээр гаргахыг хориглох барааны жагсаалтад оруулах замаар эргэлтийг хязгаарлаж, гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдлүүд болон агаар орчны бохирдол үүсгэгч томоохон эх үүсвэр болсон автомашинаас ялгарч буй утааг бууруулах боломжийг бүрдүүлэх юм.

Ингээд энэхүү “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж өгөхийг Улсын Их Хурлын гишүүдээс хүсэж байна.

Баярлалаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу?

Алга байна. /алх цохив/

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу?

Алга байна. /алх цохив/

Санал хураалтыг явуулж эхэлье.

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд тогтоолын төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн

хуралдаанд танилцуулах гишүүн байна уу?

Х.Булгантуяа
танилцуулна.

гишүүн

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудал.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл
/Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 2024 оны 04 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 2024 оны 04 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай Монгол Улсын Их Хурлын даргын захирамж гарсан байгаа.

Ингээд Та бүхэнд Байнгын хороогоор хэлэлцэхээр заасан Байнгын хорооны цаглаварын төслийг бэлтгэн тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Санал хэлэх гишүүд байна уу? Алга байна.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Гишүүддээ баярлалаа.

Хуралдаан 5 минут үргэлжилж, 12 цаг 49 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД